Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Малчдын болон малын бэлчээр, тэжээл, усан хангамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Хишигсүрэн Сайханцолмон

2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **1.1. Бэлчээрийг усжуулах, худагжуулах ажлыг үргэлжлүүлэн малын бэлчээрийн усан хангамжийн хүрэлцээг тогтвортой байлгана** | | | | | | | |
| 1 | Худаг уст цэгийг шинээр гаргах болон сэргээн засварлаж малчдад эзэмшүүлэх | ОНХС Шинээр гаргасан, сэргээн засварласан худгийн тоо | 5 | 1 | Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 1 худаг шинээр гаргах ажлыг "Таширын хүрээ" ХХК 62.0 сая төгрөгөөр гүйцэтгэж улсын комисс хүлээн авч өмчид бүртгэгдсэн. Баян-Өндөр сумын Малчин багийн Цохионы өвөрт 1 худаг шинээр гаргаж 12 өрхийн 1500 толгой мал усаар хангагдах | 10-р сар, 11-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | боломжтой болсон. | | |
| 2 | Бэлчээрт үлийн цагаан оготны тандалт судалгаа хийх. | Тандалт судалгаа хийсэн талбайн хэмжээ /га/ | 4000 | 4000 | 2024 онд нийт бэлчээрийн 10 хувь буюу 4000 га бэлчээрийн талбайд үлийн цагаан оготны тандалт судалгаа хийхээс 2024 оны 05, 10 дугаар сарууддад Ус, цаг уур орчны шинжилгээний төвтэй хамтран бэлчээрийн 4000 га талбайд судалгаа хийж ажилласан. Тандалт судалгаанд Жаргалант сумын Дулаан-Уул багийн Баруун, Зүүн булаг, Зэрэглээ, Цагаан хуст, Тугалч, Панзын далиу зэрэг газруудыг хамруулан ажиллахад бэлчээрийн хөнөөлт хортон мэрэгч, үлийн цагаан оготно илрээгүй. | 5-р сар, 6-р сар | 100% |
| 3 | Малын бэлчээрийн даацыг тодорхойлох | Малын бэлчээрийн, дундаж ургац /цн/га | 6,5 | 8.3 | Манай аймаг нийт 39.3 мянган га бэлчээрийн талбайтай. Үүнээс 1400га хадлангийн талбайгаас өвс тэжээл бэлтгэх боломжтой. Энэ жил нийт нутгаар хур тунадас ахиу орсон нь бэлчээрийн ургамлын ургалтад сайнаар нөлөөлж ургамлын өндөр 2-15см байна. УЦУОШТ-тэй хамтран 2024 оны 08 дугаар сарын 12-14-ны өдрүүдэд | 8-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Баян-Өндөр, Жаргалант сумдын бэлчээрийн 7 цэгээс 35 дээж авч ургамлын ургац тодорхойлоход бэлчээрийн га-ын ургац нь 8.3 ц/га байна. 1400га хадлангийн талбайгаас 4500тн хадлан бэлтгэх боломжтой байна.Өвөл хаврын бэлчээрийн даац нутгийн 30 хувьд мал өвөлжилт, хаваржилт хэвийн байхаар харин 70 хувьд бэлчээрийн даац 3-5 дахин хэтэрсэн. | | |
| **1.2. Мал аж ахуйг байгаль, цаг уурын эрсдэлээс хамгаалах, бэлэн байдлыг хангах, сумдад өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх, тэжээлийн үйлдвэрлэл нэмэгдүүлнэ.** | | | | | | | |
| 4 | Аймаг, сумын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэх | Өвс, тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэлт /хувь/ | 100 | 100 | Засгийн газрын 2024 оны 28-р тогтоолын хүрээнд аймгийн хэмжээнд 130 тн өвс, 85 тн тэжээл бэлтгэхээс 160 тн өвс, 75 тн тэжээл бэлтгэсэн. Үүнээс аймгийн өвс, тэжээлийн аюулгүй нөөцөд 60 тн өвс, 25 тн тэжээл, Баян-Өндөр сум 50 тн өвс, 20 тн тэжээл, Жаргалант сум 50 тн өвс, 30 тн тэжээлийг тус тус бэлтгэсэн. Аймаг, сумдын аюулгүйн нөөцийн өвс, тэжээлийг нийт-196.5 сая төг-өөр бүрдүүлсэн. | 10-р сар, 11-р сар, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | Малчдын түвшинд байгалийн хадлан бэлтгэх, тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх | Бэлтгэсэн байгалийн хадлан, тэжээл /тн/ | 9710 , 390 | 11722, 481 | Аймгийн хэмжээнд малчдын түвшинд 11500 тн байгалийн хадлан бэлтгэхээс Баян-Өндөр сум -4000 тн, Жаргалант сум 7500 тн бэлтгэхээр төвлөсөн. Малчид өөрсдийн нөөц бололцоогоороо байгалийн хадлан 11722 тн, сүрэл 150 тн, үйлдвэрийн тэжээл 480 тн, ногоон тэжээл 1428 тн, гар тэжээл 107 тн, дарш, ногооны хаягдал 263.3 тн, хужир, шүү 310 тн-ыг тус тус бэлтгэж биелэлт 102.4 хувьтай хангасан. | 9-р сар, 10-р сар | 100% |
| **1.3. Бэлчээрийн менежментийг сайжруулах** | | | | | | | |
| 6 | Малын тооноос хамааралтайгаар бэлчээрийн татварыг бий болгох, татварыг бий болгох, татварыг орон нутгийн санд төвлөрүүлэх, түүнийг бэлчээрийн нөхөн сэргээхэд ашиглах эрх зүй, | Бэлчээрийн татвар тушаасан малчдын | 598 | 600 | 2024 600 малчин малын тоо толгойн албан татвар төвлөрүүлж тус зардлаас бэлчээр хамгаалах өдрийг тохиолдуулан Жаргалант сумын малчин, мал бүхий иргэдэд өвөлжөө хаваржааны бэлчээрийг эрт чөлөөлөхийн ач холбогдол, бэлчээрийн хортон мэрэгчдийн талаар танилцуулга бэлтгэн, зөвлөмж тарааж, малчдын түвшинд тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор "Өвөлжөө, хаваржааны бууцны хөл газар"-т | 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бүтэц, зохион байгуулалтын нөхцөлийг бүрдүүлэх | | | | ногоон тэжээл тариалах сургалтыг Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн, Жаргалант сумын Засаг даргын Тамгын газартай хамтран зохион байгуулж 97 малчин өрхөд 5.1 тн овьёосны үр, хашаа олгож, тариалалт 95 хувьтай хийгдсэн. 1 малчин өрх өвөлжөө, хаваржааны бууцны хөл газар 0,3-1 га талбайд ногоон тэжээл тариалсан. Нийт 42,5 га талбайгаас 170тн ногоон тэжээл бэлтгэж дундажаар 1 малчин өрх 2тн ногоон тэжээл хураан аваад байна. | | |
| **2.1. Малчдыг мэдээллээр хангаж, орон нутагтаа ая тухтай ажиллаж, амьдрах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ** | | | | | | | |
| 7 | Малчдад төрийн үйлчилгээг хүргэх | Төрийн үйлчилгээ хүргэсэн малчин мал бүхий иргэдийн тоо | 725 | 930 | Аймгийн Засаг даргын А/42 дугаар захирамж, “Малын генетик нөөцийн тухай” хууль, “Мал амьтны эрүүл мэндийн тухай” хуулийг малчдад сурталчлан таниулах, хүн, мал эмнэлэг, төрийн үйлчилгээг үзүүлэн мал аж ахуйн өвөлжилт, хаваржилтын цаг үеийн байдалтай танилцах, “Малчдад тусалъя” аяны хүрээнд | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 9-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | цугласан хандив, эрүүл мэндийн багцыг хүргэхээр Баян-Өндөр, Жаргалант сумдад 1, 2, 3, 9 дүгээр саруудад давхардсан тоогоор 1263 малчин өрхийн 1297 иргэнд хүн эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлсэн. Аймгийн хэмжээнд Мал аж ахуйн салбарын хаваржилт хүндэрсэн тул аймгийн Засаг даргын 2024 оны А/130, А/146 дугаар захирамжийн хүрээнд нэмэлтээр 2000 боодол өвс, 178.5 тн буюу 7142 шуудай тэжээл, 1670 ширхэг ашигт долооц, 600 кг биобэлдмэлийг 1179 малчин, мал бүхий өрхөд үнэгүй олгосон. | | |
| 8 | Малчдад сургалт зохион байгуулах | Зохион байгуулсан сургалтын тоо | 2 | 3 | 1. Шинэ зууны мал аж ахуйн хөгжлийг орон нутагт түгээн дэлгэрүүлэх залуу малчдыг чадавхжуулах зорилгоор Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах орны хашаалсан бэлчээрт малыг | 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тэжээх, эдийн засгийн тооцооллыг оновчтой хийх, техник тоног төхөөрөмжийг ашиглан хөдөлмөр хөнгөвчлөх, түүхий эд, бүтээгдэхүүнийг боловсруулж зах зээлд нийлүүлэх, өндөр ашиг шимт малыг төрөлжүүлэн өсгөн үржүүлэх болон мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжтэй танилцан, туршлага судлах сургалтад Жаргалант сумын 1 залуу малчин хамрагдсан.<br>2. Мал аж ахуйн биотехнологийн сургуультай хамтран Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд орон нутгийн түүхий эдээр дарш бэлтгэх арга технологийн сургалтыг 2024 оны 04 дүгээр 27-ны өдөр зохион байгуулан ажилласан. Тус сургалтад Баян-Өндөр, Жаргалант сумдын эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч болон эрхлэх сонирхолтой 65 малчин хамрагдсан. Аймгийн Засаг даргын 2024 оны А/480 дугаар захирамжийн хүрээнд Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийг чадавхижуулах, сургалтад 20 малчинг хамруулсан. | 11-р сар, 12-р сар | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Төвийн бүсийн эрчимжсэн мал аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлэхэд авч хэрэгжүүлэх төлөвлөгөөний хүрээнд хариуцлагатай мал үржүүлэг технологийн хэлэлцүүлэг болон "ШИЛМЭЛ МАЛ-2024" үзэсгэлэн худалдаанд манай аймгаас 4 ЭМАА эрхлэгч оролцож туршлага судалсан.<br>3.Малчдын түвшинд тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор "Өвөлжөө, хаваржааны бууцны хөл газар"-т ногоон тэжээл тариалах сургалтыг Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн, Жаргалант сумын Засаг даргын Тамгын газартай хамтран зохион байгуулж 97 малчин өрхөд 5.1 тн овьёосны үр, хашаа олгож, тариалалт 95 хувьтай хийгдсэн. | | |
| **3.1. Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах** | | | | | | | |
| 9 | ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж төлөвлөгөөний биелэлтийг сар бүр тайлагнаж, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад | 1-р сар,<br>2-р сар,<br>3-р сар,<br>4-р сар,<br>5-р сар,<br>6-р сар, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх | | | | тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэн ажилласан. | 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | |
| 10 | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Хууль болон эдгээрт нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлж Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд нийцүүлэн нийт 15 албан бичиг боловсруулан ажилласан. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх | | | | | 11-р сар, 12-р сар | |

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

| № | Үүрэг даалгавар | Өгсөн субъект | Биелэлт |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх** | | | | | | | |
| 1 | Мал аж ахуйн салбараас зохион байгуулсан сургалтад хамрагдах | Сургалтад хамрагдсан тоо | 3 | 3 | БОАЖЯ-наас хойд бүсийн 63 төрийн албан хаагчдыг уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдлэг, мэдээллээр хангах, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах чадавхыг бэхжүүлэх бүсчилсэн сургалт, Монголын улаан загалмайн нийгэмлэгээс зохион байгуулсан өвөлжилт, хаваржилт хүндэрсэнтэй холбоотойгоор зудын хариу арга хэмжээний яаралтай тусламжийн үйл ажиллагааны хүрээнд дунд шатны хороогоор дамжуулан малчдад нийгэм-сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх сайн дурын идэвхтэн бэлтгэх сургалт, Улсын онцгой комиссын ажлын албанаас зохион байгуулсан “Зудын сургамж” хэлэлцүүлэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, | 3-р сар, 4-р сар, 5-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар | 100% |

102

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн “Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь” төсөлтэй хамтран зохион байгуулсан “БЭЛЧЭЭРИЙН АШИГЛАЛТ, ХАМГААЛАЛТЫН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТ” сэдэвт сургалтад хамрагдсан. | | |
| 2 | Удирдлагын академиас зохион байгуулж буй сургалтад хамрагдах | Сургалтад хамрагдсан тоо | 5 | 8 | Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжих зорилгоор Төрийн албаны зөвлөл, Удирдлагын академиас зохион байгуулсан төрийн албан хаагчийн цахим сургалтанд 14 удаа хамрагдсан. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

ТАЙЛАН ГАРГАСАН:

Малчдын болон малын бэлчээр, тэжээл, усан хангамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Хишигсүрэн Сайханцолмон /......х. Саймон......../ Огноо: 2022.12.05